



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 02 өдөр

Дугаар А/535

Мөрөн сум

Жилийн эцсийн мал тооллогыг зохион
байгуулах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйл 29.1.1-ийн "г", Статистикийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь заалт, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны ээлжит 9 дүгээр хуралдааны 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жилийн эцсийн мал тооллогыг 12 дугаар сарын 07-17-ны өдрүүдэд аймгийн хэмжээнд зохион байгуулан явуулах комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, хяналтын тооллогоор сумдад ажиллах зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Мал тооллогын ажлын бэлтгэлийг бүх түвшинд сайтар хангуулж, мөрдөгдөж буй заавар журмын дагуу чанартай зохион байгуулж малыг тооллогод бүрэн хамруулах, төрийн албан хаагчдын хариуцлагыг өндөржүүлж, гарч буй зөрчил, дутагдлыг газар дээр нь залруулж, холбогдох арга хэмжээг шуурхай авч ажиллахыг мал тооллогын комиссын дарга /Ц.Баттогтох/-д үүрэг болгосугай.

3. Мал тооллогын ажлыг аргачлал, маягт заавраар бүрэн хангаж ажиллахыг Статистикийн хэлтэс /Б.Базардамбуу/-т даалгасугай.

4. Жилийн эцсийн мал, тэжээвэр амьтдын хяналтын тооллогод зарцуулах үйл ажиллагаанд шаардлагаар 5000000 төгрөгийг аймгийн Засаг даргын ерөнхий данснаас гаргаж санхүүжүүлэхийг аймгийн Ерөнхий санхүүчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Нармандах)-д зөвшөөрсүгэй.

5. Тооллогын төсөвт зардлыг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлийг жилийн эцсийн мал, тэжээвэр амьтдын хяналтын тооллого дууссанаас хойш 7 хоногийн дотор тайлагнахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Базар), Статистикийн хэлтсийн дарга (Б.Базардамбуу) нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Л.ГАНБОЛД

011115